



ДАРГА БАТЛАВ БОЛОРЖАРГАЛ

2023 оны 01 сарын 20

САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНД
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сайхан-Овоо сум

2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр үйлдэв.

Д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
1	Байгууллагын дотоод журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа эсэхэд тавих хяналт, шалгалт	1-2-р улирал	Ажлын хэсэг	Албан хаагчдын ажлын хариуцлага дээшилж, ажлын бүтээмж нэмэгдсэн байх
2	Ажлын цаг ашиглалтад тавих хяналт, шалгалт	1, 2, 3, 4-р улирал	Ажлын хэсэг	Ажилчдын ажлын үүрэг, хариуцлага, ажлын цаг ашиглалт сайжирна.
3	Хууль тогтоомж холбогдох эрх зүйн актуудыг иргэд олон нийтэд мэдээллэх, сурталчлан таниулах ажлын хэрэгжилтэд хяналт тавих	1, 2, 3, 4-р улирал	Ажлын хэсэг	Төрийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчдэд ил тод нээлттэй, түргэн шуурхай хүргэх хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.
4	Байгууллагын мөрдөж ажиллах, хэрэгжүүлэх хууль тогтоомж журам, эрх зүйн актуудын биелэлт, үр дүнгийн байдлын холбогдох стандартын хэрэгжилтэд хяналт тавих	1, 2, 3, 4-р улирал	Ажлын хэсэг	Хууль тогтоомжийн хэрэгжилт сайжирч, зөрчил дутагдалгүй ажиллана.
5	Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй байдлын холбогдох стандартын хэрэгжилтэд хяналт тавих	2, 4-р улирал	Ажлын хэсэг	Эрүүл аюулгүй ажлын орчин бүрдэнэ.
6	Байгууллагын үйл ажиллагааны чанар, хүртээмжийн байдалд судалгаа шинжилгээ явуулж сайжруулан зөвлөмж хүргүүлнэ.	1, 3-р улирал	Ажлын хэсэг	Төрийн үйлчилгээ иргэдэд ил тод шуурхай чанартай хүрч ажлын бүтээмж дээшилнэ.

7	Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл байгаа эсэхэд хяналт шалгалт хийх	2-р улирал	Ажлын хэсэг	Байгальд ээлтэй үйл ажиллагаа бий болж хандлага сэтгэлгээ тогтон ажиллаж амьдрах нөхцөл бүрдэнэ.
8	Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдалд үнэлэлт өгөх	1, 2, 3, 4-р улирал	Ажлын хэсэг	Мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
9	Байгууллагын өмчийн бүртгэл тооцоо ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт, шалгалт	2,4-р улирал	Ажлын хэсэг	Өмч хөрөнгийн бүртгэл, хамгаалалт ашиглалт сайжирч үргүй зардал буурч, эд хариуцагчийн үүрэг дээшилнэ.
10	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлд тавих хяналт, шалгалт	2, 4-р улирал	Ажлын хэсэг	Төсвийн хэмнэлттэй, үр ашигтай зарцуулалт сайжирна.
11	Төсвийн гүйцэтгэл болон Төсвийн ил тод байдалд тавих хяналт, шалгалт	2-р улирал	Ажлын хэсэг	Төсөв санхүүгийн зарцуулалт, гүйцэтгэл ил тод болно.
12	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн үйл ажиллагаа, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих, шалгалт	4-р улирал	Ажлын хэсэг	Хоршоо хөгжүүлэх сангийн зарцуулалт, гүйцэтгэл сайжирна.
13	Хууль тогтоомжийн хэрэгжилт болон өмнө нь хяналтын байгууллагаас өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих	3-р улирал	Ажлын хэсэг	Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг аривлан хэмнэх, үйл ажиллагааны үр дүн нэмэгдэх.

ДОТООД ХЯНАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ